

**Монгол хэлний дэлгэц уншигч
бэлэн боллоо (2018. 12. 26)**



Нээлтийн үйл ажиллагааны үеэр

Та бүхэн компьютер болон ухаалаг утасны дэлгэцийг харахгүйгээр зөвхөн сонсоод ашиглаж болдгийг мэдэх үү? “Дэлгэц уншигч” гэдэг нь компьютер болон ухаалаг утасны үсгэн мэдээллийг унших программ юм. Дэлхийн олон орны харааны бэрхшээлтэй иргэд боловсрол, хөдөлмөр эрхлэлт гээд өдөр тутамдаа энэхүү программыг хэрэглэдэг. Монгол хэлээрх программ хөгжүүлэлт удаан хугацаанд яригдаж ирсэн асуудал хэдий ч ИТ технологийн мэргэжилтнүүд, холбогдох байгууллагуудын хүчин чармайлтын үндсэн дээр хэрэглэгчдэд хүрэхэд бэлэн боллоо. 12-р сарын 20-ны өдөр төслийн багийнхан нээлтийн үйл ажиллагаанд оролцлоо. Нээлтийн үйл ажиллагаанд ХБИ, тэдний гэр бүлийнхэн гээд нас насны хүмүүс ирж оролцсон юм. Илүү сайхан ирээдүйд хөтлөх тус технологийн танилцуулгыг танхим дүүрэн хүмүүс чих тавин сонсоцгоож байлаа. Компютерийн дэлгэцэн дээр гарах мэдээллийг уншиж өгөх монгол хэлээрх программ нь нийгмийн оролцоог дэмжих үйл явцад томоохон хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

**Төслийн 5 дахь удаагийн Хамтарсан Зохицуулах Зөвлөл (JCC)-ийн
хурал зохион байгуулагдлаа (2019.01.17)**

JCC хурлаар Монгол Улсын Засгийн газар болон JICA хамтран төслөөс хэрэгжүүлсэн үйл ажиллагааг тайлагнахаас гадна цаашдын төлөвлөгөөг баталдаг. Энэ удаагийн хурлаар доорх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр баталлаа.

1-р сар: Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч бэлтгэх сургалт (Окинава)

2-р сар: Тайланд дахь танилцах сургалт

3-р сар: Дэд бүтцийн хүртээмжийн талаарх семинар

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Мэдээллийн лавлах номыг хэвлэх

6-р сар: Дэд бүтцийн хүртээмжийн сургалт (Нагоя) гэх мэт.

Эдгээрээс гадна Хөгжлийн бэрхшээлийн статистик мэдээлэлтэй холбоотой ажлууд, Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооны тайлан, CBID-AP 2019 (Хамт олон түшиглэн тэгш хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн орнуудын чуулган) гэх мэт маш олон ажлууд төлөвлөгдөж байна. CBID-AP 2019 чуулган нь 7-р сарын 2,3-ны өдрүүдэд болох бөгөөд Монгол Улсад анх удаагаа зохион байгуулагдах Хөгжлийн бэрхшээлийн олон улсын чуулган юм. Тус үйл ажиллагааны үр дүнд олон хүмүүс хөгжлийн бэрхшээлийн асуудлын талаар ойлголцотой болж, Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоо нэмэгдэнэ гэдэгт итгэлтэй байна.

Шинэ жилийн мэнд хүргэе ! (2018.12.27)



Хөөрхөн Сантануудтай хамт дурсгалын зураг авахуулав

12-р сарын 26-ны өдөр төслийн оффист Дауны холбооны “Нисдэг баг”-ийн залуус Шинэ жилийн мэндчилгээ дэвшүүлэхээр ирлээ. Тэд өөрсдийн гараар хийсэн хачиртай талх, гүзээлзгэнэтэй аяган тортоор бэлэг барьсан бөгөөд яг л жинхэнэ “Санта” ирсэн мэт гэнэтийн сюрприз байж чадлаа. Дашрамд нь хэлэхэд тэдний кофе шоп Зориг сангийн байрны 1-р давхарт байрладаг бөгөөд та бүхэн ажлын өдрүүдийн 11-15 цагийн хооронд үйлчлүүлэх боломжтой. Мөн кофе шопын залуус маань хүнсний бүтээгдэхүүн бэлтгэх аргаас гадна үйлчилгээ үзүүлэх арга барилд ч суралцаж байгаа гэсэн шүү! Хачиртай талх, кейкнүүд олон төрлөөр байгаа тул та бүхэн зорьж очин үйлчлүүлээрэй.

JICA DPUB фэйсбүүк хуудсанд LIKE дарж нэгдээрэй!!

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **3872** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо.

<https://www.facebook.com/jicadpub/>

Хүн ам, Орон сууцны тооллогын судалгаан дахь олон улсын хэм хэмжээг тусгасан Хөгжлийн бэрхшээлийн асуултууд (2019.01.09)



Хигашида мэргэжилтэн Нийгмийн загварын талаар тайлбарлалаа

1-р сарын 8-ны өдөр Монгол Улсын Үндэсний Статистикийн хорооноос зохион байгуулах Хүн ам, Орон сууцны тооллогын туршилтын судалгааг хийх судалгааны ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулагдлаа. Сургалтанд 56 судалгааны ажилтан хамрагдсан бөгөөд төслийн мэргэжилтэн Хигашида яриа хийлээ. Эхлээд судалгааны ажилчдаас “Хөгжлийн бэрхшээл гэж юу вэ?” гэж асуухад “Хөдөлмөрийн чадвар алдалт”, “Эрүүл мэндтэй хамааралтай сэтгэц, бие эрхтний согог” хэмээн хариулж байв. Түүнчлэн өмнөх удаагийн 2010 оны Хүн ам, Орон сууцны тооллогын асуултуудад “Хөгжлийн бэрхшээлтэй эсэх”-ийг тодруулах асуулт тусгагдсан байсан боловч Эмнэлгийн загварын ойлголтон дээр тулгуурлаж байсан юм. Энэ удаагийн судалгаа нь 2020 оны Хүн ам, орон сууцны тооллогын бэлтгэл ажлын хүрээнд хийгдэж байгаа бөгөөд Олон улсад ашиглагддаг Вашингтон группын “Богино асуулга”-ыг нэвтрүүлэх чиглэлээр холбогдох байгууллагууд ажлаа явуулж байна. Ингэснээр Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн Хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолттой нийцэхээс гадна Нийгмийн загварын ойлголт ч тусгагдах боломжтой болох юм. Гэвч холбогдох албан хаагчдын Хөгжлийн бэрхшээлийн статистикийн талаарх ойлголт өөр хоорондоо зөрүүтэй байх явдал байгаа тул төслийн зүгээс үргэлжлүүлэн сургалт семинар, хэлэлцүүлэгт оролцон, мэдээлэл хүргэх чиглэлээр ажиллах болно.

Төр, ТББ-уудын “Мэдээллийн цаг” уулзалт зохион байгуулагдлаа (2018.12.25)



10 дахь удаагийн “Мэдээллийн цаг” уулзалт 12-р сарын 19-ний өдөр зохион байгуулагдлаа. Энэ удаагийн уулзалтаар хөгжлийн бэрхшээлийн салбартай холбогдох боловсрол болон хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль, арга хэмжээний тухай төрийн холбогдох яамдуудаас мэдээлэл хийв. Мөн ТББ-аас хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой судалгааны үр дүнг танилцуулан, санал солилцлоо. Эдгээр асуудлуудын талаар төр ТББ-ууд



хэлэлцүүлэг хийн, хууль тогтоомж, бодлогыг улам сайжруулах хэрэгтэйг ярилцлаа.

DPUB Холбоо барих хаяг

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: [https:// www.facebook.com/jicadpub](https://www.facebook.com/jicadpub)

Цахим хуудас: [https:// www.jica.go.jp/project/ mongolia/015/index.html](https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html)

И-мэйл: dpub.jica@gmail.com



Ахлах зөвлөх Чуба Хусао

JICA дахь ажил

Жайка болон Тайландын Засгийн газар хамтран Ази, Номхон далайн орнуудын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийг байгуулахаар болсон. Тус төв нь Сургалт, Сүлжээ (network), ХБИ-ийн мэдээллийн төв гэсэн 3 үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд Ази, Номхон далайн орнуудын ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих, нийгэмд буй саад бэрхшээлийг арилгах чиглэлээр үйл ажиллагаа явуулах байв. Энэ нь тухайн үе буюу 2002 онд маш шинэлэг үйл ажиллагаа байлаа. Эхэндээ би Бангкокт ийм шинэ төв нээгдэх юм байна даа л гэж бодож байв. Гэтэл намайг ESCAP-д ороход дэмжлэг үзүүлж байсан Кавамура багш тус төвийн төлөвлөлтийн багт ажиллаж байсан бөгөөд надад Мэдээллийн төв болон мэдээллийн хүртээмжийг хариуцаж ажиллах уу гэсэн санал тавив. Гэнэтийн санал байсан учраас бага зэрэг бодох хугацаа хүстэл маргааш өглөө хүртэл хүлээе гэлээ. Хөөх маргааш өглөө? гэж бага зэрэг гайхсан боловч сайн бодоод үзвэл эргэлзэх шаардлагагүй санал байсан тул маргааш өглөө нь ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийллээ. (Үргэлжлэл бий...)